

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/215/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ОЗАТ ТАНАА

2024.02.23 № 231
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402334

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,326,084.00	99,415,391.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141,444.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	141,444.00	-
3121	Төгрөг	141,444.00	-
31211	Төрийн сангийн харилцах	21,444.00	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	120,000.00	-
33	АВЛАГА	-	981,751.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	981,751.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,184,640.00	98,433,640.00
354	Хангамжийн материал	11,184,640.00	98,433,640.00
35420	Аж ахуйн материал	9,761,000.00	10,110,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,423,640.00	88,323,640.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,219,842,943.23	3,814,950,057.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,219,842,943.23	3,814,950,057.86
392	Биет хөрөнгө	1,212,950,943.23	3,806,682,260.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,168,102,202.77	1,275,912,460.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(317,328,160.25)	(405,604,614.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	209,290,000.00	247,695,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(181,351,666.79)	(151,162,750.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	342,977,980.00	429,162,071.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(199,018,735.63)	(228,672,688.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,848,820.00	41,848,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,988,934.90)	(21,463,911.44)
39209	Зам, гүүрийн байгууламж	267,703,144.00	2,774,919,429.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(162,793,811.32)	(194,393,486.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	131,664,351.13	131,664,351.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(70,550,145.78)	(93,618,319.62)
39217	Ном	395,900.00	395,900.00
393	Биет бус хөрөнгө	6,892,000.00	8,267,797.70
39301	Програм хангамж	1,860,947.00	3,284,186.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,860,947.00)	(1,908,388.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,892,000.00	6,892,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,231,169,027.23	3,914,365,448.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,821,380.00	1,678,902.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,821,380.00	1,678,902.00
413	Өглөг	2,821,380.00	1,678,902.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,821,380.00	1,678,902.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,228,347,647.23	3,912,686,546.86
51	Засгийн газрын хувь оролцоо	1,228,347,647.23	3,912,686,546.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	452,639,918.40	452,639,918.40
51101	Өмч: - төрийн	452,639,918.40	452,639,918.40
512	Хуримтлагдсан үр дүн	531,956,261.27	3,216,295,160.90

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	531,956,261.27	531,956,261.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,684,338,899.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243,751,467.56	243,751,467.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,231,169,027.23	3,914,365,448.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	701,558,869.21	3,512,670,962.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	2,772,768,615.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	86,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	701,558,869.21	653,002,347.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	138,401,169.21	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	138,401,169.21	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,121,200.00	39,265,487.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,121,200.00	39,265,487.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	542,036,500.00	613,736,860.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,365,300.00	613,736,860.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	28,671,200.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	695,344,458.11	821,470,951.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,344,458.11	821,470,951.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,366,388.11	779,096,859.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,617,180.00	382,777,552.89
210101	Үндсэн цалин	198,071,344.00	272,738,205.66
210102	Нэмэгдэл	40,160,350.00	103,592,067.23
210104	Урамшуулал	1,456,510.00	6,447,280.00
210105	Гэрээт ажлын хөлс	29,928,976.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,565,200.00	48,586,937.00
210201	Тэтгэврийн даатгал	22,725,200.00	33,735,352.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,400,300.00	3,391,155.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,679,600.00	2,829,036.22
210204	Ажилгүйдлийн даатгал	523,700.00	783,807.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,236,400.00	7,847,585.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,378,900.00	37,511,700.00
210301	Гэрэл, цахилгаан	565,000.00	1,125,000.00
210302	Түлш, халаалт	33,813,900.00	36,386,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,321,900.00	39,010,270.00
210401	Бичиг хэрэг	1,101,800.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,097,300.00	33,405,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,034,800.00	3,770,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	34,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,008,700.00	1,413,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	594,500.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,008,700.00	818,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,569,500.00	5,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,569,500.00	5,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,557,100.00	33,783,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	472,600.00	32,398,294.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,900.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,800.00	588,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	131,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	251,890,908.11	230,977,005.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,008,786.00	33,102,358.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,300.00	814,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,506,822.11	197,060,647.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,978,070.00	42,374,092.11
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,380,136.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	29,380,136.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,935,800.00	16,416,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,198,500.00	15,702,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	714,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,662,134.00	25,957,892.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,662,134.00	25,957,892.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,214,411.10	2,691,200,010.61
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	6,861,110.98
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	6,861,110.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(6,861,110.98)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,214,411.10	2,684,338,899.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	563,157,700.00	653,002,347.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,157,700.00	653,002,347.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,121,200.00	39,265,487.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,121,200.00	39,265,487.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	542,036,500.00	613,736,860.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,365,300.00	613,736,860.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	28,671,200.00	

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	552,016,256.00	626,883,533.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,016,256.00	626,883,533.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,038,186.00	584,509,440.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,795,800.00	384,451,781.89
210101	Үндсэн цалин	184,632,441.00	270,621,192.35
210102	Нэмэгдэл	44,771,959.00	107,383,309.54
210104	Урамшуулал	5,542,300.00	6,447,280.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,849,100.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,565,200.00	49,036,937.00
210201	Тэтгэврийн даатгал	22,092,200.00	33,343,875.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,618,300.00	3,923,238.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,094,600.00	3,138,430.56
210204	Ажилгүйдлийн даатгал	523,700.00	783,807.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,236,400.00	7,847,585.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,378,900.00	37,511,700.00
210301	Гэрэл, цахилгаан	565,000.00	1,125,000.00
210302	Түлш, халаалт	33,813,900.00	36,386,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,028,800.00	36,812,270.00
210401	Бичиг хэрэг	1,101,800.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,804,200.00	31,105,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,034,800.00	3,770,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	136,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	177,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	177,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,008,700.00	1,483,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		594,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		70,000.00
210604	Урсгал засвар	1,008,700.00	818,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,569,500.00	5,037,000.00
210702	Дотоод албан томилолт	2,569,500.00	5,037,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,557,100.00	36,083,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	472,600.00	34,698,294.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,900.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,800.00	588,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	131,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,677,186.00	33,916,358.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,301,886.00	33,102,358.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,300.00	814,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,978,070.00	42,374,092.11
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,380,136.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	29,380,136.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,935,800.00	16,416,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	20,198,500.00	15,702,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		714,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,662,134.00	25,957,892.11

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,662,134.00	25,957,892.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,141,444.00	26,118,814.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,000,000.00	26,260,258.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,000,000.00	26,260,258.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,000,000.00	26,260,258.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,000,000.00	26,260,258.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,000,000.00)	(26,260,258.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	141,444.00	(141,444.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		141,444.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,444.00	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	531,956,261.27	1,228,347,647.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	531,956,261.27	1,228,347,647.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	531,956,261.27	1,228,347,647.23
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	531,956,261.27	1,228,347,647.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	531,956,261.27	1,228,347,647.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			2,684,338,899.63	2,684,338,899.63
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	452,639,918.40	243,751,467.56	3,216,295,160.90	3,912,686,546.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,444.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	716,498,200.00	587,800,411.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	716,498,200.00	587,800,411.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,082,000.00	571,384,211.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	401,221,500.00	384,451,781.89
210101	Үндсэн цалин	279,413,800.00	270,621,192.35
210102	Нэмэгдэл	116,807,700.00	107,383,309.54
210104	Урамшуулал	5,000,000.00	6,447,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,152,700.00	49,036,937.00
210201	Тэтгэврийн даатгал	34,103,800.00	33,343,875.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,012,200.00	3,923,238.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,800.00	3,138,430.56
210204	Ажилгүйдлийн даатгал	802,400.00	783,807.68
210205	Эрүүл мэндийн даатгал	8,024,500.00	7,847,585.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,011,700.00	37,511,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,125,000.00	1,125,000.00
210302	Түлш, халаалт	36,886,700.00	36,386,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,570,900.00	28,379,900.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,673,000.00	22,673,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,900.00	3,770,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	136,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	177,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	177,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,885,000.00	1,483,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	714,000.00	594,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	71,000.00	70,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	818,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,037,000.00	5,037,000.00
210702	Дотоод албан томилолт	5,037,000.00	5,037,000.00

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,459,200.00	42,583,394.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,414,200.00	41,198,294.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365,500.00	
210803	Даатгалын үйлчилгээ	180,600.00	180,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	399,800.00	399,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	85,000.00	85,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	838,000.00	588,700.00
210807	Газрын төлбөр	131,000.00	131,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,100.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,314,000.00	22,723,499.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,600,000.00	22,009,499.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,000.00	714,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,416,200.00	16,416,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,416,200.00	16,416,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,702,200.00	15,702,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	714,000.00	714,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	716,498,200.00	587,778,967.89
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	716,498,200.00	587,778,967.89
132001	Орон нутгийн төсвөөс	716,498,200.00	587,778,967.89
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,444.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	21
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
------------	----------	-----------

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,385,487.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,385,487.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,385,487.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,432,370.00
210402	Тээвэр, шатахуун	8,432,370.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,953,117.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,853,117.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,265,487.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,265,487.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,265,487.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах” зорилго дэвшүүлсэн байна. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллажээ.

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2023 онд шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/59 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,191.5 сая төгрөгөөр буюу 217.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	141.44	0.00	-141.44
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	11,184.64	98,433.64	87,249.00
Үндсэн хөрөнгө	1,219,842.94	3,814,950.06	2,595,107.11

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт хөрөнгө	1,231,169.03	3,913,383.70	2,682,214.67
Өр төлбөр	2,821.38	1,929.65	-891.73
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,228,347.65	3,911,454.04	2,683,106.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,231,169.03	3,913,383.70	2,682,214.67

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 98.4 сая төгрөг болж оны эхнээс 87.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Аж ахуйн материал 10.1 сая, бусад хангамжийн материал 88.3 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 17.4 сая төгрөгийн материал худалдан авч, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй 86.9 сая төгрөгийн бараа материал хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,595.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 26.3 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 2,772.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр -2,683.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 696.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 19.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.5 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 101.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 31.1 сая төгрөгөөр тус тус бууруулж, урсгал шилжүүлгийг 0.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 544.4 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 544.4 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд тус байгууллагын батлагдсан төсвийг 147.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 692.2 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 23.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.1 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 0.5 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 100.4 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 22.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 568.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 547.7 сая төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547.7 сая төгрөг буюу 96 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийг дутуу олгосон болон авсан санхүүжилтээс 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага				
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	468,709.70	449,761.62	-18,948.08	96%
2	Туслах үйл ажиллагааны зардал	91,042.30	81,385.00	-9,657.30	89%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	16,416.20	16,416.20	0.00	100%
4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	140,330.00	40,237.59	-100,092.41	29%
	Дүн	716,498.20	587,800.41	-128,697.79	82%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 39.3 сая нэмэлт санхүүжилт авсан. Үүнээс 8.4 сая төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 30.9 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 0.1 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 17.5 сая төгрөгийн бараа материал, 26.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 695.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 36 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 37.1 сая төгрөгийн 1 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.5 сая төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 11.0 сая төгрөгийн 7 шийдвэр, өр үүсгэсэн 1.9 сая төгрөгийн 1 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 60.9 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллаагүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан тул нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар суутгаагүй урьдчилгаанд 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, шилэн данс төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 61.0 сая төгрөгийн 25 шийдвэр гарсныг

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шилэн дансанд мэдээлээгүй зөрчилд албан шаардлага, 182.1 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй бүртгэж тайлагнасан зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	850.0	1	850.0	100%
Албан шаардлага	1	61,095.2	1	0	0%
Зөвлөмж	1	182,080.6	1	182,080.6	100%
Нийт дүн	1	244,025.9	3	182,930.6	74%

Тайлант оны аудитаар өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжилт 74 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 148.8 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд: Цалингийн урьдчилгааны авлагад тусгаагүй 0.3 сая, цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг илүү шилжүүлсэн 0.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг зөрүүтэй тусгасан 0.3 сая төгрөгийн, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөг 1.0 мянган төгрөгөөр дутуу, санхүүжих эх үүсвэрийг 102.8 сая төгрөгөөр дутуу, төсвийн гүйцэтгэлийг 18.9 сая төгрөгөөр илүү, санхүүжих эх үүсвэрийг 25.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан, нийт 148.9 сая төгрөгийн алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар 90.9 сая төгрөгийн зөрчил² илэрч 0.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 90.3 сая төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

1. Шилэн дансанд байршуулах цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 37.1 сая төгрөгийн 1 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 39.5 сая төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 11.0 сая төгрөгийн 7 шийдвэр, өр үүсгэсэн 1.9 сая төгрөгийн 1 шийдвэрийг байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 60.9 хувьтай байна. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.5-д “цалингийн зардлаас

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 1.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын тооцооноос газрын төлбөрт 0.6 сая төгрөгийг төлсөн байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХОАТ-ын илүү төлөлт, урьдчилгааны авлага тусгаагүй.	2	981.7	2	981.7			2	981.7				
НДШ-ийн өрийг илүү тайлагнасан.	1	250.7			1	250.7	1	250.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын 500 төгрөгөөр дутуу, санхүүжих эх	2	102,761.4			2	102,761.4	2	102,761.4				

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үүсвэрийг 102.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан												
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлагыг 18.9 сая, санхүүжих эх үүсвэрийг 25.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	2	44,946.2			2	44,946.2	2	44,946.2				
Дүн	7	148,940.0	2	981.7	5	147,958.3	7	148,940.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас илүү шилжүүлсэн 1.3 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын тооцооноос газрын төлбөрийн 578.5 мянган төгрөгийг төлсөн байна	1	578.5					1	578.5				
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	90,340.9							1	90,340.9		
Дүн	1	90,919.4					1	578.5	1	90,340.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								